

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2.Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг мөрдөж, программ хангамжид хөгжүүлэлт хийлгэж ажиллах, Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 14-өөс 2020 оны 3 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ҮАГ-ын захиалгаар “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Сайнжаргал, аудитор М.Лхагвасүрэн, аудиторын туслах П.Ганчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн дүрэмд үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Монгол улс, ард иргэдийнхээ эрх ашгийг тэргүүн ээлжинд тавьж, төслийн өгөөжийг дээшлүүлэн, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх, удирдах эрхийг хэрэгжүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон байна.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Оюу Толгой ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх;
- Хувьцаа эзэмшигчийн хувьд “Оюу Толгой” ХХК-ийн үйл ажиллагаанд оролцох
- Оюутолгойн ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх;
- Төрд ногдох ашгийг төвлөрүүлэх. Үүнд:
 - “Оюу Толгой” ХХК-ийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого
 - Хөрөнгө оруулалтаас орох цэвэр ашгийг төвлөрүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэс Оюу Толгой ХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Мэжик финанс программ хангамж ашиглаж байна.

“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад санхүүгийн тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,638.8 сая төгрөгөөс тооцон 16.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 583.8 сая төгрөгөөр буюу 33.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	56.3	34.0	(22.3)
Авлага	14.7	1.2	(13.5)
Бараа материал	2.9	2.9	-
Үндсэн хөрөнгө	91.8	81.9	(9.9)
Биет бус хөрөнгө	0.6	0.4	(0.2)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,720,175.9	2,304,003.6	583,827.7
Нийт хөрөнгө	1,720,342.2	2,304,124.0	583,781.8
Өр төлбөр	7,754.9	9,333.0	1,578.1
Төрийн өмч	300.0	300.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	1,720,175.9	2,304,003.6	583,827.7
Хуримтлагдсан ашиг алдагдал	(7,888.6)	(9,512.6)	(1,624.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,720,342.2	2,304,124.0	583,781.8

Өмнөх оны үзүүлэлтээс урт хугацаат хөрөнгө оруулалт, авлага данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Урт хугацаат хөрөнгө оруулалт 583,827.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Оюу Толгой ХХК-ийн гаргасан хувьцааны Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 34%-д ногдох өөрчлөлтөөс үүссэн.

Авлага дансны үлдэгдэл 13.5 сая төгрөгөөр буурсан нь түрээсийн байр өөрчлөгдсөний улмаас өмнөх байрны түрээсийн барьцаа төлбөр 11.5 сая төгрөг буцааж авсан, тайлант хугацааны ХХОАТ, болон НДШ-ийн авлага 2.0 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ. Авлага дансны 1.2 сая төгрөгийн үлдэгдэл нь Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоо байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,578.1 сая төгрөгөөр өссөн нь толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн санхүүжилт 825.0 сая, санхүүжилтийн хүүгийн өглөг 740.2 сая, ХХОАТ-ын өглөг 12.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Өглөгийн данс 9,333.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Татварын өглөг 12.9 сая, Эрдэнэс Монгол ХХК-д өгөх зээлийн өглөг 6,681.0 сая, зээлийн хүүгийн өглөг 2,639.0 сая төгрөг тус тус байна.

Эздийн өмчийн бусад хэсэг 583,827.7 сая төгрөгөөр өссөн нь Оюу Толгой ХХК-ийн гаргасан хувьцааны Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 34%-д ногдох өөрчлөлтөөс үүссэн байна.

2.9.Зорилтот түвшин гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Хувьцаа эзэмшигчийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 2019 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдсан байна. Эрдэнэс Монгол ХХК болон Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн хооронд 2017 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 0412017 тоот “Зээлийн гэрээ” байгуулан охин компанийн 2017-2022 он хүртэлх үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг Эрдэнэс Монгол ХХК-аас зээл хэлбэрээр шийдвэрлэхээр гэрээнд тусгажээ.

Хүснэгт 1. Орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Санхүүжилт	1,147.2	825.0	322.2	71.9
Хүүгийн орлого	1.0	1.0	-	
Нийт дүн	1,148.2	826.0	322.2	71.9

Тайлант онд Эрдэнэс Монгол ХХК-аас 825.0 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төлөвлөгөөнөөс 322.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Хүснэгт 2. Зардлын гүйцэтгэл

/сая төгрөг/

Зарлагын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалингийн зардал	634.2	484.9	149.3	76.5
НДШ	69.8	63.1	6.7	90.4
Бичиг хэрэг, шуудан холбооны зардал	23.1	14.5	8.6	62.8
Түлш шатахууны, сэлбэг хэрэгсэл, тээврийн зардал	25.1	8.6	16.5	34.3
Байрны урсгал засварын зардал	8.0	0.5	7.5	5.7
Гадаад томилолт	80.0	59.7	20.3	74.6
Түрээсийн төлбөр	82.0	21.7	60.3	26.4
Бусад зардал	188.0	178.4	9.6	94.9
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	38.0	17.0	21.0	44.8
Нийт зардлын дүн	1,148.2	848.2	299.9	73.9

2019 онд үндсэн үйл ажиллагаанд 1,148.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 848.2 сая төгрөг зарцуулж 73.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Компанийн бүтэц орон тоо 17 ажилтан ажиллахаар батлагдсанаас 13 ажилтан ажиллаж цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 156.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Түрээсийн байр өөрчлөгдөн талбайн хэмжээг багасгаснаар түрээсийн зардал 60.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж, нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 22.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 11.0 сая төгрөгийн алдааг залруулж, 1.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 9.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 9.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Журам батлах тухай 2019 оны 271 тоот тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх,

данснаас хасах, шилжүүлэх" журмын 1.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн

2. Томилолтын зардлыг 1.1 сая төгрөгөөр илүү олгосон нь Сангийн сайдын "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2011 оны 188 дугаар тушаал, 2018 оны 301 дүгээр тушаалтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчилд төлбөрийн акт тогтоосон

Аудитаар илэрсэн 2 алдаа зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэс Оюу Толгой ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэртэй холбоотой 38 мэдээлэл хугацаанд нь байршуулсан 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жилийн эцэст хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ний 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хуулийн дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Мөнгөн гүйлгээний тайланд түрээсийн зардал программаас татагдахдаа санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний хэсгийн зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн хэсэгт тайлагнагдаж байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-тай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Сангийн сайдын тушаал хэрэгжихгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг мөрдөж, программ хангамжид хөгжүүлэлт хийлгэж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана

3.2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Шилэн дансанд байршуулах зарим мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч, 6 дугаар зүйлийн "6.1.1-д тухайн жилийн төлөвлөгөө жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор мэдээлнэ",

6.9-д ... Засгийн газар түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр ... шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулна“ гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалт хэрэгжүүлж ажиллаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг бүрэн байршуулж байх, хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	56,317,827.49	34,040,040.72
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	3,145,019.62	1,208,877.63
1.1.4	Бусад авлага	11,525,198.91	
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	2,946,770.00	2,946,770.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	73,934,816.02	38,195,688.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	91,763,891.00	81,907,242.70
1.2.2	Биет бус хөрөнгө	573,694.00	373,694.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,720,175,940,000.00	2,304,003,540,000.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,720,268,277,585.00	2,304,085,820,936.70
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,720,342,212,401.02	2,304,124,016,625.05
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	42,025.06	12,917,439.10
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг	1,898,769,086.61	2,639,046,015.38
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,898,811,111.67	2,651,963,454.48
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	5,856,054,430.00	6,681,054,430.00
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,754,865,541.67	9,333,017,884.48
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	300,000,000.00	300,000,000.00
2.3.2	Өмч-хувийн		

2.3.3	Өмч-хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,720,175,940,000.00	2,304,003,540,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-7,888,593,140.65	-9,512,541,259.43
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,712,587,346,859.35	2,294,790,998,740.57
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,720,342,212,401.02	2,304,124,016,625.05

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)		
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	820,548.32	964,111.63
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		250,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	807,968,863.92	898,384,397.25
11	Санхүүгийн зардал	619,469,213.68	740,276,928.77
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	73,969.80	28,519.22
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-1,426,543,559.48	-1,637,418,695.17
19	Орлогын татварын зардал	82,054.83	171,411.16
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,426,625,614.31	-1,637,590,106.33
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,426,625,614.31	-1,637,590,106.33
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн		
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		21,446,493.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого		21,446,493.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	728,634,197.16	793,011,451.43
1.2.1	Ажиллагчдад төлсөн	451,989,388.16	442,905,513.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	102,000,000.00	105,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		14,506,948.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	120,000.00	22,114,119.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,932,500.00	8,628,750.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	55,074,945.00	18,411,636.18
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	108,517,364.00	181,444,485.25
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-728,634,197.16	-771,564,958.43
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	820,548.32	964,111.63
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	820,548.32	964,111.63
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8	Бусад мөнгөн орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	23,289,420.00	76,710,190.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,289,420.00	17,033,960.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		59,676,230.00
2.2.6	Бусад мөнгөн зарлага		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-22,468,871.68	-75,746,078.37
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	832,993,840.00	825,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	832,993,840.00	825,000,000.00

3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад мөнгөн орлого		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	71,993,840.00	0
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	71,993,840.00	0
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5	Бусад мөнгөн зарлага		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	761,000,000.00	825,000,000.00
4	Валютын ханшийн зөрүү	73,969.80	33,250.03
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9,970,900.97	-22,277,786.77
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	46,346,926.52	56,317,827.49
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	56,317,827.49	34,040,040.72

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Эздийн өмчийн бусад хэсэг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	300,000,000.00	6,461,967,526.34	1,550,000,000,000.00	1,543,838,032,473.66
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00		0.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		1,426,625,614.31	170,175,940,000.00	168,749,314,385.69
7	Тайлант үеийн үр дүн				
8	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	300,000,000.00	7,888,593,140.65	1,720,175,940,000.00	1,712,587,346,859.35
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		13,641,987.55		13,641,987.55
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	300,000,000.00	7,874,951,153.10	1,720,175,940,000.00	1,712,600,988,846.90
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00			0.00
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
15	Тайлант үеийн үр дүн		1,637,590,106.33	583,827,600,000.00	582,190,009,893.67
16	Гаргасан капитал				0.00
17	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	300,000,000.00	9,512,541,259.43	2,304,003,540,000.00	2,294,790,998,740.57

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд баталгаажуулах	Аудитын код:
2020,03,11			САГ-2020/77/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө худалдан авсан.	9.9	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Түмэнцогт, Г.Мөнхтөр
2	Томилолтын зардлыг илүү олгосон.	1.1	Акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Түмэнцогт, Г.Мөнхтөр
3	Мөнгөн гүйлгээний тайланг буруу илэрхийлсэн байна		Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Түмэнцогт, Г.Мөнхтөр
4	Шилэн дансанд байршуулах зарим мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.		Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Түмэнцогт, Г.Мөнхтөр
	ДҮН	11.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 23

№ 02/153

Улаанбаатар хот

С АГ-2020/77/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэргүйгээр 9,886,460.00 /есөн сая найман зуун наян зургаан мянга дөрвөн зуун жаран/ төгрөгийн хөрөнгө худалдан авсан. зөрчил илэрсэн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "журам батлах тухай 2019 оны 271 тоот тогтоол", "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 1.2 Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй;

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө худалдан авсан зөрчлийг арилгах; давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах,
2. Дээрх асуудлуудын биелэлтийг 2020 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн захирал Ц.Түмэнцогт, ерөнхий нягтлан бодогч Г.Мөнхтөр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:

УАГ-ЫН САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АУДИТОР **Ц.НАРАНЧИМЭГ**

ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК
ЗАХИРАЛ **И.ЭРДЭНЭЦЭЦЭГ**

Ч.ЭНХТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ **Ц.ТҮМЭНЦОГТ**

Г.МӨНХТӨР

Акт, албан шаардлагын биелэлт хангаагаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 23

№ 02/70

Улаанбаатар хот

СБГ- 20 20/77/СТА- 704Г

Төлбөр барагдуулах тухай




Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


- Томилолтын зардлыг илүү олгосон 1,079,101.00 /нэг сая далан есөн мянга нэг зуун нэг/ төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 болон Сангийн сайдын “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2011 оны 188 болон 2018 оны 301 дүгээр тушаалыг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 95 тоот тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3. “Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон,” заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Томилолтын зардал илүү олгосон 1,079,101.00 /нэг сая далан есөн мянга нэг зуун нэг/ төгрөгийг 2020 оны 4 дугаар сарын 10-ны өдрийн дотор буруутай албан тушаалтнаар төлүүлэх, Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн захирал Ц.Түмэнцогт, ерөнхий нягтлан бодогч Г.Мөнхтөр нарт даалгав.

АКТ:

ӨГСӨН:
 УАГ-ЫН САНХҮҮГИЙН АУДИТЫН
 ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
 АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ
 АУДИТОР  И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
 ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК
 ЗАХИРАЛ  Ч.ЭНХТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:
 ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН
 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ 
 Ц.ТҮМЭНЦОГТ
 ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
 Г.МӨНХТӨР

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТЭМДЭГЛЭЛ

Lined writing area with 20 horizontal dotted lines.